

**2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 06 дугаар сарын 12-ны “Даваа” гарагийн 12:00 цагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т word файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	2023 оны 06 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуульд нийт байгууллагуудын удирдлага, ажилтан, албан хаагчид идэвхтэй оролцох.	ААНБ-ууд
2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнг нэгтгэн танилцуулах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ
3	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/323 дугаар захирамжийн дагуу нийтийн эзэмшлийн газарт болон эзэмшиж, ашиглаж байгаа газраа дур мэдэн нэмэгдүүлж, зохих зөвшөөрөлгүйгээр хашаа, хайс барьсан зөрчлийг арилгах, газар чөлөөлөх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ГЗБА
4	“Үндэсний соёл амралтын хүрээлэн”-д 2023 оны 06 дугаар сарын 09, 10, 11-ний өдрүүдэд “ICT EXPO-2023” арга хэмжээ зохион байгуулагдах тул холбогдох албан тушаалтнуудыг оролцуулах арга хэмжээ авах (Мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдыг оролцуулах)	ААНБ-ууд
5	Нийслэлийн хэмжээнд “Сити дашбоард” нэвтрүүлсэнтэй холбогдуулан дараах 3 модулиудад мэдээллүүдийг 7 хоног тутамд шинэчлэн оруулах. Үүнд 1. Санхүү, төсвийн модуль, 2. Хөрөнгө оруулалтын модуль, 3. Аюулгүй байдлын модуль зэрэг ажлууд	ЗДТГ, ААНБ-ууд
6	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд эхний хагас жилд төлөвлөсөн ажлууд эрчимжүүлж, гүйцэтгэл, үр дүнд тогтмол хяналт тавьж, дээд шатны байгууллагуудад гаргадаг тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллах.	ЗДТГ, ААНБ-ууд
7	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн явган хүний зам, авто замын засвар, арчлалт, гэрэлтүүлгийн асалт, засвар үйлчилгээний нөхцөл байдлыг газар дээр явж шалгах ажлуудыг зохион байгуулах.	ЗДТГ, ТХҮХ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
8	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн бордюрын эвдрэлийг засварлах ажлыг эрчимжүүлж, 2023.06.11-ний өдрийн дотор гүйцэтгэж ажиллах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
9	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо 50 м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээж, цэвэрлэгээг тогтмолжуулж, хайс хашааг угаах, хогны түүвэр цэвэрлэгээг хийх, байгууллага бүр 50 м ² -аас доошгүй талбайд ногоон байгууламж нэмэгдүүлэн, усалгаа, арчилгааг тогтмолжуулж ургуулахад анхаарах.	ААНБ-ууд

10	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагынхаа ажилтан, албан хаагчдад үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллах.	ААНБ-ууд
11	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд веб сайтад холбогдох мэдээллийг бүрэн оруулж, үнэлгээг дээшлүүлэхэд анхаарч ажиллах	ЗДТГ
12	2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдах дүүргийн 1 дүгээр хорооны “Сууц өмчлөгчдийн холбоо”-ны хурлын ирцийг бүрдүүлэхэд анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, 2 дугаар хорооны СӨХ-ны хурлын товыг тогтоох.	ТХҮХ, ААНБ-ууд, Хороод
13	“Багахангай 2040” хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг ажлаа эрчимжүүлэн танилцуулах	ЗДО Б.Болормаа, Ажлын хэсэг
14	ААНБ-ууд Олон улсын байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлаа эрчимжүүлэх.	ААНБ-ууд
15	Зам засварын ажлын гэрээг эцэслэж ажлыг эхлүүлэх, өнгөрсөн онд чанаргүй гүйцэтгэсэн зам засварын ажлыг яаралтай гүйцэтгүүлэх.	ЗДО Б.Болормаа СТСХ, ТХҮХ
16	2023.06.13-ны өдөр зохион байгуулагдах “Адуучин” тэмцээний бэлтгэлийг сайтар хангаж, аюулгүй байдлыг ханган ажиллах.	ЗДЗ Г.Дагвадорж, НХХ, Цагдаагийн хэлтэс, ОБХ, ЭМТ